



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/186

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн
бэлтгэл шатны сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1046 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2023 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу алба хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлага олгох тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 18-наас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн 323 дугаар салбарын байрлалд зохион байгуулсугай.

2.Сургалтад хамрагдах цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шаардагдах 2,215,000 (Хоёр сая хоёр зуун арван таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Сургалтыг хариуцлагатай зохион байгуулж, хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (Дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД